



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/39

Булган сум

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Х.Мөнхтогтох (ГЭ71123106)-ын Булган сум 5 дугаар баг Агуулахын товог 1 дүгээр гудамж 109в тоотод байршилтай гэр, орон сууц хашааны зориулалтаар эзэмшиж буй 40 м² газрыг 63 м² болгон илүү талбайн дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн кадастрын зургийн дагуу газрын хэмжээг өөрчилж, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.

2. Х.Мөнхтогтохтой газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны Б/85 дугаар захирамжийн Х.Мөнхтогтохтой холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6320011154